



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

**ЗОСТ ХҮҮХДИЙН ЗУСЛАНГ ХУВЬЧИЛСАН ШИЙДВЭР ХУУЛЬ
ТОГТООМЖИД НИЙЦЭЭГҮЙ БАЙНА**



2023 оны 11
дүгээр сар

АУДИТЫН СЭДЭВ:
ХҮҮХДИЙН ЗУСЛАНГИЙН ХУВЬЧЛАЛ, ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ

Товчилсон үгийн тайлбар	3
Хавсралтын товъёг:	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4
А1. Хүүхдийн зусланг хувьчлах үнийг тогтоосон шийдвэр холбогдох хууль, тогтоомжид нийцээгүй байна	6
А1.1 Зост хүүхдийн зусланг удирдлагын гэрээгээр ажиллуулж байсан иргэнд давуу эрхээр хувьчилсан байна	6
А1.2. Хүүхдийн зусланг хувьчлахаас өмнө худалдах доод үнийг хууль журмын дагуу тогтоосон байна.....	7
А1.3 Аймгийн ИТХ-ын хүүхдийн зусланг хувьчлах үнийг тогтоосон шийдвэр нь холбогдох хууль, тогтоомжид нийцээгүй байна	8
А2. Хүүхдийн зусланг хувьчлах үйл ажиллагаа холбогдох хууль, тогтоомжийн дагуу явагдсан байна	8
А2.1 Зост хүүхдийн зусланг удирдлагын гэрээгээр олон жил ажиллуулсан иргэнд давуу эрхээр хувьчилсан байна	8
А2.2 Аймгийн ИТХ-ын шийдвэрээр тогтоосон хувьчлах үнийг төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.....	8
А3. Хувьчилсан иргэнтэй гэрээ байгуулаагүй, шийдвэрийн хэрэгжилтийг дүгнээгүй, үр дүнг нь тооцоогүй байна	9
А3.1 Орон нутгийн өмчийн газар хүүхдийн зусланг хувьчилж авсан иргэнтэй гэрээ байгуулаагүй байна	9
А3.2 Хувьчилсан шийдвэрийн хэрэгжилтэд холбогдох байгууллагаас хяналт хэрэгжүүлээгүй байна	9
ДҮГНЭЛТ:	12
ЗӨВЛӨМЖ:.....	13

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Хавсралтын товьёг:

Дүрслэл №01	Зост зуслангийн барилгад их засвар хийж буй байдал	10
Дүрслэл №2	Зост зусланд амарч буй хүүхдүүдийг төрөл бүрийн арга хэмжээнд хамруулж байгаа талаар	11

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2023 оны “Тушаалд нэмэлт оруулах тухай” А/67 дугаар тушаалаар баталсан “Хүүхдийн зуслангийн хувьчлал, хууль тогтоомжийн нийцэл”-д аудит хийх төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

“Хүүхдийн зуслангийн хувьчлал, хууль тогтоомжийн нийцэл” сэдвээр нийцлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж гарган, Аймгийн ИТХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитын гүйцэтгэв.Үүнд:

- Хүүхдийн зусланг хувьчилсан шийдвэрүүд холбогдох хууль, тогтоомжид нийцсэн эсэх.
- Хүүхдийн зусланг хувьчлах үйл ажиллагаа холбогдох хууль, тогтоомжийн дагуу явагдсан эсэх.
- Хувьчилсан шийдвэр, гэрээний биелэлтийг дүгнэж үр дүнг тооцсон эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймгийн ИТХ, Засаг дарга, Орон нутгийн өмчийн газраас Зост хүүхдийн зуслангийн хувьчлалтай холбоотой үйл ажиллагаа болон “Зост Өлгий” ХХК-ийн зуслангийн үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг хамруулав.

Аудитын хязгаарлалт

Байхгүй

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100-400, 4000, 4001, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 MNS Тулгуур зарчим, 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудит, Нийцлийн аудитын заавар аргачлал, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Женисбек хянан удирдаж, чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Назгүл, аудитор С.Нурлан нар хамтран гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 01-ний хооронд гүйцэтгэж, тайлангийн төслийг бэлтгэн холбогдох үе шатны хяналтаар хянуулан аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн тушаалаар баталгаажуулж, 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ҮАГ-ын ГНАГ-т, 11 дүгээр сарын 17-ны дотор холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Хүндрэл бэрхшээл

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас Зост хүүхдийн зуслангийн хувьчлалтай холбоотой аудитад шаардлагатай баримт материалыг ирүүлээгүй, 2018 оноос өмнө тус газрын даргаар ажиллаж байсан хүмүүс тэтгэвэр гарсан зэрэг нь аудитын ажилд хүндрэл бэрхшээл учруулсан болно.

Аудитад Аймгийн ИТХ, ОНӨГ болон “Зост Өлгий” ХХК-иас ирүүлсэн баримт, материалд үндэслэж аудитыг хэрэгжүүлсэн.

A1. Хүүхдийн зусланг хувьчлах үнийг тогтоосон шийдвэр холбогдох хууль тогтоомжид нийцээгүй байна

A1.1 Зост хүүхдийн зусланг удирдлагын гэрээгээр ажиллуулж байсан иргэнд давуу эрхээр хувьчилсан байна

Зост хүүхдийн зуслан Баян-Өлгий аймгийн Буянт сумын нутагт Зост гэдэг газарт 1986 онд 240 хүүхдийн байр, Соёлын төв, гуанз, захиргаа аж ахуйн байр, нийт 15 модон барилга объект баригдан ашиглалтад орсноор үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. Газарзүйн байршлын хувьд аймгийн төвөөс 60 км-т, ой модгүй, Сагсай голын эрэгт байрладаг.

Зост хүүхдийн зуслан нь 2003 он хүртэл аймгийн Хүүхдийн төлөө төвийн харьяанд үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

УИХ-ын 2002 оны 56 дугаар тогтоолоор баталсан "Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл"-ийн 1.3¹, 1.4², 1.5.3³-д заасан заалтуудыг үндэслэж аймгийн ИТХ-ын 2003 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор Зост хүүхдийн зусланг нийтийн дуудлага худалдаагаар худалдахаар шийдвэрлэж, бэлтгэл ажлыг хууль, журмын дагуу хийж, худалдах доод үнэ, хугацааг аймгийн ИТХ-д оруулан шийдвэрлүүлэх талаар аймгийн Орон нутгийн өмчийн албанд үүрэг болгосон байна.

Аймгийн ИТХ-ын 2003 оны 31 дүгээр тогтоолын дагуу Зост хүүхдийн зусланг хувьчлах шийдвэр гарч олон нийтэд зарласан боловч тухайн үед хувьчлалд оролцох талаар байгууллага, иргэдээс санал ирээгүй байна.

УИХ-ын 2002 оны 56 дугаар тогтоолоор баталсан "Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл"-ийн 1.4-т "Удирдлагын, гүйцэтгэлийн, түрээсийн гэрээгээр ажиллуулах журмыг Төрийн өмчийн хороо холбогдох төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн баталж, хэрэгжилтэд хамтран хяналт тавина" гэснийг үндэслэн Зост хүүхдийн зусланг удирдлагын гэрээгээр ажиллуулах талаар шийдвэр гарч тухайн байгууллагад олон жил удирдах албан тушаал эрхэлж байсан иргэнд өгсөн байна.

Зост хүүхдийн зусланг 2003 онд 10 жилийн хугацаагаар удирдлагын гэрээгээр ажиллуулахаар өгсөн бөгөөд 2007 онд гэрээний хугацааг 2017 он хүртэл дахин 10 жилээр сунгасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 3-т "Менежментийн гэрээг төсөл сонгон шалгаруулалтын үндсэн дээр хуульд өөрөөр заагаагүй бол 3 хүртэл жилийн хугацаагаар бичгээр байгуулна" гэсэн заалттай нийцээгүй байна.

Удирдлагын гэрээний хугацаанд Зост хүүхдийн зусланг ажиллуулж байсан иргэн нас барсан тул аймгийн ИТХ-ын 2014 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн "Удирдлагын гэрээгээр ажиллуулах эрх шилжүүлэх тухай" 67 дугаар тогтоолоор зуслангийн менежерээр ажиллаж байсан түүний хүүхдэд эрх шилжүүлж, удирдлагын гэрээний хугацааг 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл ажиллуулахаар гэрээний хугацааг хэвээр баталсан байна.

¹ 1.3. Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх зарчим;

² 1.4. Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлалыг хэрэгжүүлэх арга хэлбэр

³ 1.5.3 Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт

Аймгийн Орон нутгийн өмчийн алба аймгийн ИТХ-ын 2014 оны 67 дугаар тогтоолын дагуу хүүхдийн зусланг гэрээгээр ажиллуулах иргэнтэй 2014 оны 05 дугаар сарын 12-ны өдөр гэрээ байгуулсан байна.

Зост хүүхдийн зуслан ашиглалтад орсноос хойш улсын болон орон нутгийн төсвөөс ямар нэг хөрөнгө оруулалт хийгдээгүй байна.

Хүүхдийн зуслангийн модон барилгууд элэгдэж хуучирсны улмаас үйл ажиллагаа зогсох эрсдэлд орсныг харгалзан удирдлагын гэрээгээр эрх шилжүүлж авсан иргэн аймгийн ИТХ-д 2015 онд зусланг хувьчилж авах талаар санал оруулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1⁴, 34.1.6⁵, 81 дүгээр зүйлийн 81.1⁶-д заасны дагуу аймгийн ИТХ-ын 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор хуулийн 77 дугаар зүйлийн 77.3⁷-т заасан бүрэн эрхийн хүрээнд Зост хүүхдийн зусланг түрээсийн давуу эрхээр хувьчилсан байна.

Хувьчлах орон нутгийн эд хөрөнгийн жагсаалтыг батлахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.3-т “орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах ба бусдад шилжүүлэх, шинээр олж авах жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийг хэлэлцэж батлах. Хувьчлах орон нутгийн эд хөрөнгийн жагсаалтыг батлахдаа Төрийн өмчийн хороотой зөвшилцөнө” гэсний дагуу зөвшилцсөн эсэх талаар холбогдох нотлох баримт ирүүлээгүй.

Аймгийн Засаг дарга Зост хүүхдийн зусланг хувьчлахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.6⁸-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлсэн талаар холбогдох баримт материал ирүүлээгүй.

А1.2. Хүүхдийн зусланг хувьчлахаас өмнө худалдах доод үнийг хууль журмын дагуу тогтоосон байна

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д “Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлахын өмнө хувьчлах эд хөрөнгийг энэ хуулийн 37, 70 дугаар зүйлд заасны дагуу тооллого, үнэлгээ хийж, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтад шилжүүлнэ”, 37 дугаар зүйлийн 37.1-д “Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлахаас өмнө худалдах доод үнийг тогтооно” гэж заасан байна.

⁴ 34.1. Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлахдаа дараахь аргыг дангаар буюу хослуулан хэрэглэнэ,

⁵ 34.1.6 менежментийн үр дүнг харгалзан хувьчлах

⁶ 81.1 “Орон нутгийн өмчийг хувьчлах арга, хэлбэр, журмыг энэ хуулийн зургадугаар бүлэгт заасныг удирдлага болгон иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.”;

⁷ 77.3. орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах ба бусдад шилжүүлэх, шинээр олж авах жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийг хэлэлцэж батлах. Хувьчлах орон нутгийн эд хөрөнгийн жагсаалтыг батлахдаа Төрийн өмчийн хороотой зөвшилцөнө;

⁸ 78.6. орон нутгийн өмчийн эд хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэрэгжил, арга зүйн удирдлагын дор хувьчлах ажлыг зохион байгуулах,

Зост хүүхдийн зусланг хувьчлахаас өмнө Монгол Улсын эрх бүхий хөрөнгийн үнэлгээчнээр зуслангийн байшин барилга, байгууламж үл хөдлөх хөрөнгөд тухайн үеийн зах зээлийн үнийг тодорхойлох, үнэлгээ хийлгэсэн байна.

Хөрөнгийн үнэлгээчний Зост хүүхдийн зуслангийн үл хөдлөх хөрөнгийг үнэлсэн тухай тайланд “2023 оны 05 дугаар сарын 16-ны байдлаар Зост зуслангийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, машин механизмын хамт иж бүрнээр үнийг 50.0 сая төгрөгөөр тогтоосон” тухай дүгнэлт гаргасан байна.

А1.3 Аймгийн ИТХ-ын хүүхдийн зусланг хувьчлах үнийг тогтоосон шийдвэр нь холбогдох хууль, тогтоомжид нийцээгүй байна

Аймгийн ИТХ-ын 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор Зост хүүхдийн зусланг 30.0 сая төгрөгөөр хувьчлах шийдвэр гаргасан байна.

Хөрөнгийн үнэлгээчний хөрөнгө үнэлсэн үнэлгээний тайланд хувьчлахаас өмнө буюу 2016 оны 05 дугаар сарын 16-ны өдөр зуслангийн үл хөдлөх зах зээлийн үнэлгээг 50.0 сая төгрөгөөр тогтоосон.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 69 дүгээр тогтоол нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т “Хөрөнгийг доод үнээс доогуур үнээр худалдахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитын дүнгээр Аймгийн ИТХ-ын 2016 оны 69 дүгээр тогтоол Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг зөрчиж байгаа тул хүүхдийн зусланг тухайн үеийн зах зээлийн үнээс доогуур үнээр худалдсан үнийн зөрүү 20.0 сая төгрөгийг “Зост Өлгий” ХХК-наар төсөвт нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

А2. Хүүхдийн зусланг хувьчлах үйл ажиллагаа холбогдох хууль, тогтоомжийн дагуу явагдсан байна

А2.1 Зост хүүхдийн зусланг удирдлагын гэрээгээр олон жил ажиллуулсан иргэнд давуу эрхээр хувьчилсан байна

Аймгийн ИТХ-ын 2016 оны 69 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хуулийн 77 дугаар зүйлийн 77.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд 81 дүгээр зүйлийн 81.1⁹, 34 дүгээр зүйлийн 34.1¹⁰, 34.1.6¹¹-д заасны дагуу “Зост” хүүхдийн зусланг 2016 онд түрээсийн давуу эрхээр хувьчлах шийдвэр гаргасан тул сонгон шалгаруулалт явагдаагүй байна.

А2.2 Аймгийн ИТХ-ын шийдвэрээр тогтоосон хувьчлах үнийг төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна

⁹ 81.1 “Орон нутгийн өмчийг хувьчлах арга, хэлбэр, журмыг энэ хуулийн зургадугаар бүлэгт заасныг удирдлага болгон иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.”.

¹⁰ 34.1. Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлахдаа дараахь аргыг дангаар буюу хослуулан хэрэглэнэ,

¹¹ 34.1.6 менежментийн үр дүнг харгалзан хувьчлах

Аймгийн ИТХ-ын 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор Зост хүүхдийн зусланг 30.0 сая төгрөгөөр хувьчлах шийдвэр гарсны дагуу хувьчилж авсан иргэн аймгийн Орон нутгийн өмчийн албаны Төрийн банк дахь 598800227512 тоот дансанд 2016 оны 05 дугаар сарын 24-ний өдөр 15.0 сая төгрөг, 2016 оны 05 дугаар сарын 27-ны өдөр 15,0 сая төгрөг, нийт 30.0 сая төгрөгийг бүрэн төлсөн байна.

А3. Хүүхдийн зусланг хувьчилж авсан иргэнтэй гэрээ байгуулаагүй, шийдвэрийн хэрэгжилтийг дүгнээгүй, үр дүнг нь тооцоогүй байна

А3.1 Орон нутгийн өмчийн газар хүүхдийн зусланг хувьчилж авсан иргэнтэй гэрээ байгуулаагүй байна

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1-д “Орон нутгийн өмчийг хувьчлах арга, хэлбэр, журмыг энэ хуулийн зургаадугаар бүлэгт заасныг удирдлага болгон иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно” гэж заасан.

Аймгийн Орон нутгийн өмчийн алба Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 61 дүгээр зүйлийн 61.1-д “Хувьчилсан эд хөрөнгийг өмчлөгч этгээдэд шилжүүлэхийн өмнө Төрийн өмчийн хороо шинэ өмчлөгчтэй эд хөрөнгө хувьчилсан тухай гэрээ байгуулна” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, Зост хүүхдийн зусланг хувьчилж авсан иргэнтэй гэрээ байгуулаагүй байна.

А3.2 Хувьчилсан шийдвэрийн хэрэгжилтэд холбогдох байгууллагаас хяналт хэрэгжүүлээгүй байна

Аймгийн Засаг дарга нь төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2 дахь зүйлийн 1 дэхь хэсэгт “иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах”, 6 дахь хэсэгт “орон нутгийн өмчийн эд хөрөнгийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэргэжил, арга зүйн удирдлагын дор хувьчлах ажлыг зохион байгуулах” гэсэн эрх үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Зост хүүхдийн зусланг удирдлагын гэрээгээр ажиллуулсан хугацаанд өмч хөрөнгө нь орон нутгийн өмч байсан боловч Аймгийн Орон нутгийн өмчийн албанаас зуслангийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Зост хүүхдийн зусланг хувьчлах үеэр удирдлагын гэрээний биелэлтийг дүгнээгүй, өмч хөрөнгийн тооллого хийгдээгүй, хөрөнгийг албан ёсоор хүлээлцэх ажил хийгдээгүй байна. Энэ нь тухайн үед Хүүхдийн зуслан менежментийн гэрээгээр эзэмшиж байсан иргэнд давуу эрхээр хувьчилсантай холбоотой байна.

Мөн үйл ажиллагааны чиглэлээр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт харьяалагдаж байсан боловч хамтарч үйл ажиллагаа явуулаагүй байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн алба Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1¹², 65.2¹³, 65.3¹⁴ дахь заалтуудыг зөрчсөн ба тус албаны удирдлагад тухайн үед ажиллаж байсан хүмүүс тэтгэвэрт гарсан тул хариуцлагын асуудал ярих боломжгүй болсон байна.

Аудитын дүнгээр аймгийн Орон нутгийн өмчийн газарт цаашид хөрөнгийн хувьчлалтай холбоотой зөрчлийг давтан гаргахгүй байх, хувьчлалтай холбоотой баримт материалыг цаасаар болон цахимаар архивын нэгж үүсгэн хадгалах, хүүхдийн зусланг хувьчилж авсан иргэнтэй гэрээ байгуулж, хуулийн дагуу хяналтыг хэрэгжүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөмж өгөв.

Хувьчлагдсанаас хойших “Зост Өлгий” ХХК-ны үйл ажиллагааны талаар товч танилцуулахад:

“Зост Өлгий” ХХК нь хүүхдийн зусланг хувьчилж авснаас хойш үйл ажиллагааг тасралтгүй явуулж ирсэн бөгөөд хүүхдийн амрах орчныг сайжруулах зорилгоор 2018 онд арилжааны банкнаас 80.0 сая төгрөгийн зээл авч зуслангийн 4 байранд их засвар хийж ор, хөнжил, ширээ, сандал, гал тогооны хэрэгслүүдийг шинэчилсэн байна. /Дүрслэл №1/

Дүрслэл №1 Зост зуслангийн барилгад их засвар хийж буй байдал



Эх сурвалж: “Зост Өлгий” ХХК-ны үйл ажиллагааны тайлангаас

¹² 65.1-д “Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчилсан тухай бүр хувьчлалыг эрхлэн явуулсан этгээд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.”

¹³ 65.2-т “Тайланд гэрээ, хөрөнгийн жагсаалтыг тус тус хавсаргана. Тайлан нь төрийн өмчийн тухай эд хөрөнгийг хувьчилсан тухай нотлох хуулийн үндсэн баримт бичиг бөгөөд түүнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

¹⁴ 65.3-т “Баталсан тайланг зохих журмын дагуу архивт тусгай сан хөмрөг болгон шилжүүлнэ.”

Хүүхдийн зуслан нь улирлын чанартай 6, 7, 8 дугаар саруудад үйл ажиллагаа явуулдаг бөгөөд жил бүр 6 ээлжид давхардсан тоогоор 400-500 хүүхэд тогтмол хүлээн авдаг байна. /Дүрслэл №2/

Дүрслэл №2 Зост зусланд амарч буй хүүхдүүдийг төрөл бүрийн арга хэмжээнд хамруулж байгаа талаар



Эх сурвалж: Зост Өлгий ХХК-ны үйл ажиллагааны тайлангаас

Зост хүүхдийн зуслан нь 2020-2021 онд ковид өвчин гарсантай холбоотой үйл ажиллагаа явуулаагүй байна.

Нийт 17 ажилтныг улирлаар гэрээгээр ажиллуулдаг бөгөөд 9 багш, 9 ажилтантай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоо болон Өлгий сумын 13 багийн нийгмийн ажилтнуудтай хамтран ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот бүлэг, нэн ядуу өрхөд амьдарч буй хүүхдийн судалгааг авч жил бүр 60-80 хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот бүлгийн хүүхдийг хөнгөлөлттэй үнээр амруулдаг байна.

Үүнээс гадна аймгийн Ахмадын холбоотой хамтран жил бүр 30 ахмадыг хөнгөлөлттэй үнээр амруулдаг байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Хүүхдийн зусланг удирдлагын гэрээгээр ажиллуулж байсан иргэнд давуу эрхээр хувьчилсан байна.
2. Зост хүүхдийн зусланг хувьчлах үнийг тогтоосон шийдвэр нь хууль, тогтоомжид нийцээгүй байна.
3. Хүүхдийн зусланг хувьчилсан үнийг төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.
4. Хүүхдийн зусланг хувьчилсан иргэнтэй гэрээ байгуулаагүй, шийдвэрийн хэрэгжилтийг дүгнээгүй, хяналт хэрэгжүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

I. Орон нутгийн өмчийн газрын дарга Т.Назым-д:

1.Хөрөнгийн хувьчлалтай холбоотой зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх, хувьчлалтай холбоотой баримт материалыг цаасар болон цахимаар архивын нэгж үүсгэн хадгалах, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

2.Хүүхдийн зусланг хувьчилж авсан иргэнтэй гэрээ байгуулж, хуулийн дагуу хяналтыг хэрэгжүүлж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 7 дугаар сарын 01-ний дотор ирүүлэнэ үү.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:

1.Аймгийн Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн санал


**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**
83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас: 7042-2201

2023.11.15 № 01/323
танай _____ -ны № _____ -т

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР М.ХУАНГАН ТАНАА

Аймгийн Засаг даргын 2016 оны 09 дүгээр сарын 12-ний өдрийн А/488 дугаар захирамжаар орон нутгийн өмчийн алба болон худалдан авах ажиллагааны алба нь татан буугдан Орон нутгийн өмчийн газар болж байгуулагдсан ба тухайд үед ажиллаж байсан албан хаагчдад Зост хүүхдийн зусланг хувьчилсантай холбоотой ямар нэгэн баримт бичгүүдийг хүлээлгэж өгөөгүй болно.

ДАРГА  Т.НАЗЫМ
9003700 8311134345

C:\Users\PC\Desktop\blank
202311150501



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/24

Өлгий

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1-ийн 1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүүхдийн зуслангийн хувьчлал, хууль тогтоомжийн нийцэл" сэдвээр хийсэн нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг аймгийн Засаг дарга, Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэхийг ахлах аудитор (Д.Назгүл)-д үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Назым)-д, төлбөрийн актыг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор барагдуулахыг "Зоост Өлгий" ХХК-ны захирал (Б.Нурбек)-д зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 5 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтуудыг архивын нэгж болгон бичиг хэрэгт хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Д.Назгүл)-д үүрэг болгосугай.



Х.ЖЕНИСБЕК